

Хэнтий аймгийн Монгол Ардын Хувьсгалт Намын
2020 оны 06 дүгээр сарын ~~22~~²³ днийн
хуралдаанаар хэлэлцэж батлав.

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН
ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

“ИРГЭДЭЭ ДЭМЖДЭГ ХАН ХЭНТИЙ” ХӨТӨЛБӨР

ЗОРИЛГО:

Монгол Ардын Хувьсгалт Нам нь Хэнтий аймгийн иргэдийнхээ нийтлэг эрх ашгийг удирдлага болгож экологийн чиг баримжаатай улс төр нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгож, иргэдээ төрөлх нутагтаа сэтгэл хангалуун амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

НЭГ. ИРГЭН ТАНЫ АМЬДРАЛД:

- Төрийн болон хувийн хэвшлийн салбарт нас, хүйс, намын харьяаллаар ялгаварлан гадуурхахыг таслан зогсооно.
- 0-2 насны хүүхдээ асарч байгаа эцэг эхчүүдэд тухайн орон нутгийн төсвөөс амьдрах хэмжээнд хүрэхүйц “баталгаатай орлого”-ыг олгох судалгаа хийнэ.
- Жирэмсэн эмэгтэйчүүд 3-5 насны хүүхэдтэй ажилчин, ажилтныг ажиллуулж буй аж ахуйн нэгжүүдийг татварын бодлогоор дэмжинэ.
- “Хан-Хэнтийн оюунлаг иргэн” төлөвшүүлэх зорилгоор хүүхэд бүр амьдралын түвшнээс үл хамааран цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн болон Их дээд сургуульд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх,
- 0-5 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрт дэмжлэгийн хөтөлбөр боловсруулах судалгаа хийнэ.
- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих зорилгоор иргэд биеийн тамирыг хүн бүрийн амьдралын эрүүл дадал болгох нөхцөл бололцоог нээхийн зэрэгцээ “ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАЛ”, “ЗӨВ ХҮНС” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Хэнтий аймгийн залуучуудаа төр засгийн зардлаар дээд боловсрол олгож, нарийн мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулна.
- Иргэн бүрийн эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний зардлыг төрийн өмчийн эмнэлгээр үйлчлүүлэхэд орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх талаар судалгаа хийж бодлого боловсруулна.
- Ажлын байрыг нэмэгдүүлэх замаар иргэдээ орлогын баталгаатай эх үүсвэртэй болгоно.

- Иргэдийн авах цалин амьдралд нь хүрэлцэхүйц байх, ингэснээр хөдөлмөрийн хөлсөөрөө сайхан амьдрах боломжийг бүрдүүлнэ.
- Ядууралд өртсөн иргэдээ “Хүрэлцэхүйц орлого”-той болгох, ядуурлыг бүрмөсөн арилгах бодлого боловсруулна.

ХОЁР. ӨРХ, ГЭР БУЛИЙН АМЬДРАЛД:

Монгол Улсын тулгуур баялаг нь “Монгол өрх” мөн тул аймаг, сумын төвүүдэд амьдарч буй өрх гэр, залуу гэр бүл, иргэдийг тохилог орон сууцанд амьдрах бодлогыг боловсруулан өрх бүрийг орон сууцаар хангах зорилт тавьж ажиллана.

Үүнд:

- Монгол хүн эх орондоо эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг дээдлэж “Өрх бүрт орон сууц хөтөлбөр”-ийг Хэнтий аймагт хэрэгжүүлэх эдийн засгийн эх үүсвэрийг судлана.
- Аймгийн төв, сумдад хувийн орон сууц барих бодлогыг дэмжинэ.
- Бичил болон өрхийн бизнесийг дэмжих талаар Хэнтий аймаг, сумын төвүүдэд зөвлөх үйлчилгээг үзүүлэх төвүүд байгуулж нас насны онцлогт тохирсон тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих санхүү, зээлийн төвүүдийг байгуулж, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгож айл өрх, аж ахуйн нэгжийн орлого, бизнесийн боломжийг нэмэгдүүлэх замаар ажлын байрыг шинээр бий болгоно.

ГУРАВ. АЙМАГ, СУМЫН ХҮРЭЭНД:

- “Уул уурхайгүй Хан Хэнтий” бодлого боловсруулан ажиллана.
- Хэнтий аймгийг аялал жуулчлалын бүс болгож хөгжүүлэх замаар иргэдийнхээ амьжиргааг дэмжинэ.
- Аймаг орон нутгийн төрийн үйлчилгээний шат дамжлагуудыг цөөлж, бүх шатны байгууллагуудыг авлигаас ангид байлгах бодлого боловсруулна.
- Орон нутгийн төр засгийн байгууллага, албан тушаалтнууд хариуцлага хүлээдэггүй өнөөгийн гаж тогтолцоог халж Монгол хүнийг хамгаалдаг иргэндээ ээлтэй нутгийн захиргааны шинэ тогтолцоонд шилжинэ.
- Аймгийн агаарын болон хөрсний бохирдол, орчны бохирдол, дэд бүтцийн асуудлыг цогцоор шийдвэрлэн цэвэр агаар, эрүүл хөрс, ногоон байгууламж бүхий экологийн тэнцвэртэй орчныг бүрдүүлнэ.
- Залуучуудад зориулсан гарааны бизнесийг дэмжих “Старт апп” хөтөлбөрийг хэрэгжүүлж, бизнес эрхлэгч залуучуудад зориулсан “Дундын оффис” сум бүрт байгуулна.
- Хэнтий аймагт “Эмэгтэйчүүдийн хөгжил сан” байгуулж эмэгтэйчүүдийн эрхэлж буй бизнесийг дэмжинэ.
- Аймаг, сумын төвүүдэд жил бүр 100 гарааны бизнесийг дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд зориулсан ажлын цагийн уян хатан нөхцөлтэй ажлын байрууд бий болгоно.



- Ахмадуудыг төр засгийн байгууллагад сайн дурын зөвлөхөөр авч ажилуулж, ахмад мэргэжилтнүүдийг зохих урамшуулалтайгаар ажиллуулсан ААН-үүдийг татварын тогтолцоогоор урамшуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сувилал, сэргээн засах төвийг аймагт байгуулах ажлыг эхлүүлнэ.
- Аймаг, орон нутагт ногоон орчин, гол ус бүхий орчинд иргэдийн оролцоотой байгальд ээлтэй “Эко сум” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Иргэд амьдрах таатай эрүүл цэвэр, ногоон технологи бүхий хаягдалгүй орчинг иргэдийн оролцоотойгоор бүрдүүлнэ.
- Аймаг, сумын төвүүдэд Төр хувийн хэвшлийн оролцоотой хүүхэд, залуучуудын хөгжих орчин нөхцлийг бүрдүүлсэн цэнгэлдэх хүрээлэн, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах эрхийг аж ахуйн нэгжүүдэд чөлөөтэй олгоно.
- Аймаг, сумын төвүүдэд хөдөө аж ахуйн бүтээгдхүүн, малын гаралтай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх эрх зүйн өөрчлөлтийг хийнэ.
- Хүнсний аюулгүй байдлыг ханган, малын гаралтай эцсийн бүтээгдэхүүнийг экспортлон малчдын орлогыг төрөлжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор малыг эрүүлжүүлэх аяныг өрнүүлнэ.
- Сумдад “Цагаан алт” болох ноосыг боловсруулах, жижиг дунд үйлдвэр байгуулахыг дэмжинэ.
- Алслагдсан сумдын бэлчээрийг худаг усаар хангах бодлого боловсруулна.
- Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг нэмэгдүүлэн хүүхдэд ээлтэй ногоон орчин бүрдүүлэх бодлогыг дэмжиж хэрэгжүүлнэ.
- “Эрүүл зөв амьдрал”, “Зөв хүнс” хөтөлбөрийг нэн тэргүүнд цэцэрлэг, сургууль, олон нийтийн үйлчилгээний газруудад хэрэгжүүлнэ.
- Багш нарыг орон сууцжуулах, хөдөө орон нутагт багшлах боловсон хүчнийг дэмжих, сургалтад хамруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор аймаг, сумын засаг даргын дэргэд “Багш” сан байгуулж ажиллуулна.

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ

